

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газар нь: 2019 онд “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “2019 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн ажил”-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. /Энэхүү зөвлөх үйлчилгээ нь авто замын зураг төсөл боловсруулах ажил юм./

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын гэрчилгээний наториатоор батлуулсан хуулбар
- Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл /наториатоор батлуулсан хуулбар, гэрээний хамт /
- Харилцагч Татварын алба, Нийгмийн даатгал, банк, Шүүх болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолтууд
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт
- Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ижил төрлийн ажлын туршлагын талаарх мэдээлэл
- Ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын мэдээлэл

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019 оны 06 дугаар сарын 07-ноос 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрүүдэд ажлын цагаар** авч болох бөгөөд мэдүүлгээ төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад өөрийн аж ахуйн нэгжийн нэвтрэх эрхээр орж **2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 11 цаг 00** минутаас өмнө цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

**Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг,
Нутгийн удирдлагын ордны 2-р давхар 208 тоот өрөө
Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар
Утас: 70546204, 99038561**